

НИЙСЛЭЛИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Монгол орон мал аж ахуйн орон бөгөөд олон зууны туршид нүүдлийн мал аж ахуйг эрхлэн амьдарч ирэхдээ малын өвчин эмгэгийг өөрийн уламжлалт аргаар буюу өвс ургамал хэрэглэх, хатгаж, төөнөх гэх мэт аргацаах төдийгээр 20 дугаар зуунтай золгосон байна.

20 дугаарт зууны эхэн үеэс эхлэн барууны буюу европын /Орос/-ын эм, эмчлэх арга аажмаар нэвтэрч, энэ нь нэг талаас улс орнууд хөгжиж, хөгжихийн хирээр бараа таваарын солилцоо эрчимтэй явагдаж байсан ч нөгөө талаар мал, амьтны элдэв халдварт халдваргүй өвчин Монгол орны хил хязгаарыг нэвтрэн орж ирэх үзэгдэл жилээс жилд нэмэгдэж байсан юм.

Монгол оронд 19 дүгээр зууны сүүлч, 20 дугаар зууны эхээр гадаадын /ихэвчлэн Оросын/ худалдаачид ихээр ирж, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуурыг худалдан авч, Орос руу гаргах, Оросоос өргөн хэрэглээний хүнс, хувцас хэрэгсэл оруулж ирж худалдан борлуулдаг байсан байна.

Монгол орны мал сүрэгт элдэв төрлийн ялангуяа халдварт өвчин эмгэг мялзан, шүлхий, цэцэг, годрон, цээж, боом гэх зэрэг өвчнүүд хил нэвтрэхэд нь саад болж, тэдгээр худалдаачдын ашиг орлогыг бууруулж байсан тул худалдаж авсан мал сүргийг нутагт нь эмчлэх, сэргийлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн түүхтэй.

1905-1920 оны хооронд эхлээд Оросын нутаг Чита мужид дараа Монгол орны хойд хэсэг Сэлэнгэ аймгийн Ерөө гол орчимд, мөн Да хүрээ буюу Улаанбаатар хот орчмын Сонгинын булан, Налайхын гол үхрийн мялзанг эмчлэн сэргийлэх тарилга вакцин үйлдвэрлэлийн газар жижиг станц байгуулж, худалдаж авсан малаа вакцинжуулдаг байсан байна.

Энэ ажил нь Монгол орны нутаг дэвсгэрийн өчүүхэн хэсэг, цөөхөн тооны мал сүргийг хамарч байсан ч малчин түмний таашаалыг хүлээж байсан юм.

Үүнээс үндэслэн Ардын засгийн газар анх удаа ард түмний амьдралын үндэс болсон мал сүргийг өвчин эмгэгээс эмчлэн эдгэрүүлэх төдийгөөр бус, харин урьдчилан сэргийлэх, улмаар устган эрүүлжүүлж чадах шинжлэх ухааны мал эмнэлгийг байгуулан, хөгжүүлэх үйл явдлыг түүхэн эхлэлийг тавьсан юм.

1923 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Ардын Засгийн газрын тогтоолоор Нийслэл хүрээ болон Сонгинын булан гэсэн 2 салбартай “Мал эмнэлгийн хэлтэс”-ийг Сангийн яамны дэргэд байгуулсан, удалгүй 08 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолоор дээрхи хэлтсийг Дотоод явдлын яаманд харьяалуулж, “Мал эмнэлгийн хэрэг эрхлэх газар” болгосон.

Ардын Засгийн газрын 1923 оны шийдвэрээр байгуулагдсан Дотоод явдлын яамны дэргэдэх мал эмнэлгийн хэрэг эрхлэх газрын харьяанд Нийслэл хүрээний мал эмнэлгийг байгуулж, П.Жүрмэдийг даргаар нь, сургагч даргаар нь малын их эмч П.И Орловыг, мэргэжлийн сургагчаар малын их эмч А.А.Дудуколов нарыг томилон 12 орон тоотой ажиллахаар баталсан байна.

Нийслэл хүрээний мал эмнэлэгт тухайн үед ажиллаж байсан малын эмч нар нь ЗХУ-аас уригдаж ирсэн хүмүүс байсан ба ганц монгол хүн байсан нь Монгол Улсын анхны малын эмч Очирын Лувсанбалдан байсан байна.

Ийнхүү шинэ үеийн Монгол оронд болон нийслэл хотод шинжлэх ухааны мал эмнэлгийн байгууллага үүсэн байгуулагдаж, түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн юм.

2013 онд Нийслэл хотод мал эмнэлгийн байгууллага байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн.

Сайд нарын зөвлөлийн 1977 оны 05 дугаар тогтоолоор байгуулагдсан Мал эмнэлгийн газар нь Нийслэлийн Засаг даргын 1998 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/110 дугаар захирамжаар бүтцийн өөрчлөлт орж, Нийслэлийн мал эмнэлэг, хяналтын алба болсон.

2000 онд Монгол Улсын Засгийн газрын 185 дугаар тогтоолоор Мал эмнэлэг, хяналтын газар, 2003 онд Мэргэжлийн хяналтын газар байгуулагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2003 оны 39 дүгээр захирамжаар Мал эмнэлэг, үржлийн газар, 2005 онд нийслэл хотод Хөдөө аж ахуйн асуудлыг хариуцдаг Хөдөө аж ахуйн газар байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн газар болон тус тус өөрчлөгдсөн.

Нийслэлийн мал эмнэлгийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, нийслэлийн 9 дүүрэг, 3 тосгонд үйл ажиллагаа явуулж буй мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд, хүнсний зах, худалдааны төвийн дэргэдэх мал эмнэлэг, ариун цэврийн лабораториудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг.

Тус газар нь Нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, шаардлага, стандартад нийцсэн мал эмнэлгийн үйлчилгээг иргэд, байгууллагад үзүүлдэг тэргүүлэх байгууллага болох, Мал, амьтны өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, хүнсний аюулгүй байдлын баталгааг хангах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад орчин үеийн шинжлэх ухааны онол арга зүйд тулгуурласан үйл ажиллагаа явуулах алсын хараа, эрхэм зорилготой.

Нийслэл хотод хүн ам ихээр төвлөрөх болсонтой холбогдуулан хүн амын хүнсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж, 2013 онд мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд химийн бодис, хүнд металлын үлдэгдэл, цацраг идэвхит бодис тодорхойлох хүчин чадалтай багаж тоног төхөөрөмжөөр хангагдаад байна.

Нийслэлийн мал эмнэлгийн газар нь 2011 оноос 33 орон тоотой, мал эмнэлгийн алба, мал эмнэлгийн лаборатори, захиргаа аж ахуй, хангамж үйлчилгээний алба гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна.

Цаашдаа дараах стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллана.

1.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын мал эмнэлгийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх

2.Мал, амьтны өвчлөлтийн байдлыг нийслэлийн хэмжээнд бүртгэх, хянах, мэдээлэх, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын гоц халдварт, халдварт,

паразиттах өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг бодлого, хөтөлбөр, төслийн хүрээнд дотоодын болон олон улсын стандарт, заавар, арга зүйн дагуу хэрэгжүүлэх

3. Мал эмнэлгийн лабораторийн оношлогоо шинжилгээний чадавхийг бэхжүүлж, мал эмнэлгийн анхан шатны нэгжүүдийн ажил үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж, баталгаажуулалт олгох

4. Мал эмнэлгийн лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог MNS (ISO) IEC 17025 стандартад нийцүүлж, боловсронгуй болгож төгөлдөржүүлэх

5. Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, боловсон хүчнийг сургаж мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах

6. Мал эмнэлгийн ажил үйлчилгээнд мэдээллийн технологийг нэвтрүүлж, цахим сан бүрдүүлэх

7. Нохой, гэрийн тэжээмэл амьтдын эмнэл зүйн үзлэг, шинжилгээ хийх орчин үеийн шаардлагад нийцсэн амбулатори, клиник лабораторийг бэхжүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, бэлтгэх

8. Байгалийн давагдашгүй хүчин зүйлүүд /ган, зуд, үер ус, газар хөдлөлт, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчин гэх мэт/-ийн үед мэргэжлийн байгууллагуудын чиг, үүргийг удирдлага болгон, ажлын уялдаа холбоог сайжруулж, шуурхай зохион байгуулан ажиллах.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж, график, төлөвлөгөөтэй ажлуудыг цаг хугацаанд нь гүйцэтгэдэг болсон байна.

Нийслэлийн Мал эмнэлгийн газар нь Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Хүнс, хөдөө аж ахуйн яаманд харьяалагдах хоёрдмол удирдлагатай. Харьяанд:

-Дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд

-Хувийн хэвшлийн мал эмнэлгийн лабораториуд

Хоёр. Хөмрөгийн баримтын түүх

1996 оноос тус газрын архив, бичиг хэргийн эрхлэгчээр П.Дэмбэрэлням ажиллаж, байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг байгуулан, ажиллуулж, 1999 онд Нийслэлийн архивын газарт төрийн архивт шилжүүлэх хугацаа болсон 66 ХН, 20 кг баримтыг шилжүүлсэн байна.

Мөн архиваас лавлагаа, хуулбар хувь олгох, баримт түр ашиглуулах бүртгэлийг тогтмол хөтөлж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг жил бүр батлуулан ажиллаж байна.

2006 онд Нийслэлийн архивын газартай гэрээ байгуулан 1988-2005 оныг хүртэлх байнга хадгалах 30 ХН-ийг тус газраар ЭШТБ-ын ажлыг гүйцэтгүүлэн хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Архивын газрын нөхөн бүрдүүлэлт хийх хувиарын дагуу Нийслэлийн Мал эмнэлгийн газрын архивын эрхлэгч П.Дэмбэрэлням миний бие Нийслэлийн Архивын

газрын Төлөвлөлт арга зүйн хэлсийн зааварлагч арга зүйч Н.Цацралтуяагаас өгсөн мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөний дагуу Нийслэлийн Архивын газрын 98 дугаар хөмрөгт хадгалагдаж буй Нийслэлийн мал эмнэлгийн газрын байнга хадгалах 1953-1995 оны 74 хадгаламжийн нэгж Мөн Нийслэлийн мал эмнэлгийн газрын байнга хадгалах 1988-2005 оны 50 хадгаламжийн нэгж данс 2-ийн үргэлжлэх данс болгон 2005-2009 оны баримтыг төрийн архивын сан хөмрөгт хүлээлгэн өгч 2010-2013 оны баримтыг байгууллага дээр хадгалах болж. Мөн түр, 70 жил хадгалах баримтуудыг тус тусад нь ангилан төрөлжүүлж эмх цэгцтэй хадгалж байна

Байгууллагын архивт хадгалагдаж байгаа баримтын бүрдлийн хувьд:

- Дээд газрын тогтоол, захирамж, газрын даргын тушаал, хурлын тэмдэглэл, Нийгэм эдийн засгийн зорилт , Засгийн газрын, Нийслэлийн Засаг Даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт, газар, хэлтсийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, хөтөлбөрийн хэрэгжилт , урьдчилан сэргийлэх болон лабораторийн жилийн эцсийн мэдээ баримтууд байнгын бүртгэл бүрдэж байна.
- Даргын боловсон хүчний тушаал, цалингийн хүснэгт, цалингийн карт, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан зэрэг баримтуудаас бүрдэж байна.
- Дээд газраас ирсэн цаг үеийн шинж чанартай тогтоол, шийдвэр, ирсэн, явуулсан бичиг, бүртгэлийн дэвтрүүд, ажиллагсдын үр дүнгийн гэрээ, биелэлт, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан, мэдээ, хөтөлбөрийн улирал, хагас жилийн хэрэгжилт, шуурхайн мэдээ, журнал, харилцах, мөнгөн хөрөнгийн баримт, кассын баримт, нягтлан бодох бүртгэлийн баримт, ажилчдын үр дүнгийн гэрээ, цагийн бүртгэл, мал амьтаны тоон тайлан зэрэг баримтуудаас бүрдэж байна.
- Тус газрын түүх дурсгалтай холбоотой гэрэл зураг, цомог зэрэг баримтуудаас бүрдэж байна.

Эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлын явцад дараах ажлыг хийж гүйцэтгэх явцад:

- Газрын даргын тушаалыг 2008-2013 оны үйл ажиллагааны болон боловсон хүчний асуудлаар 2 ангилан он, сар, өдрийн дараалалд оруулж, хуудас дугаарлах, үдэж хавтаслах, нуруу цаас наах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Дээд газраас ирсэн тогтоол, захирамж, ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг ач холбогдол, хадгалах хугацаагаар нь байнга, түр болгож ангилан, байнга хадгалагдах ирсэн, явуулсан бичгийг 2008 оноос эхлэн байнга, түр хадгалах хугацаагаар ангилан төрөлжүүлж хэрэг бүрдүүлж авсан.
- Үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс тухайн жилд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жилийн төлөвлөгөө, тайлан, холбогдох баримтуудыг байнга салган авч, сар, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан мэдээг түрд үлдээв.
- Түрийн бүртгэлээс 2005-2009 оны цалин, ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 70 жилд авч, 70 жилд хадгалах хэргийг бүрдүүлэн техник боловсруулалтын ажлыг хийсэн. 2005 -2009 оны касс харилцахын баримтаас цалин, нийгмийн даатгал , жилийн эцсийн тайлан, мэдээг түүсэн.
- 2010-2013 оны Санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан зэрэг нь санхүүгийн баримтад хамт үдэгдсэн, санхүүгийн баримтын шалгалтад ороогүй, хадгалах хугацаа нь дуусаагүй тул задлалгүй түрийн бүртгэлд нь үлдээв.

- 2008-2009 оны байгууллагад ирсэн бичиг явуулсан бичгийн байнга , түр хадгалах гэж ангилсан.
- 1997- 2004 оны нийгмийн даатгалын тайлангаас төсвийн гүйцэтгэлийн мэдээг салгаж байнга хадгалах нэгжид авсан.
- 1995-2005 оны өргөдөл, гомдол, байгууллагын сар , улирлын мэдээ, төлөвлөгөө, тайлан, шуурхайн мэдээ, ажиллагсдын үр дүнгийн гэрээ, ирсэн явуулан бичиг, ирсэн явсан бичгийн бүртгэлийн дэвтэр, цагийн бүртгэл , касс харилцах, харъяа байгууллагад хяналт хяналт шалгалт хийсэн баримт бичиг зэргийг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 10 хэргийн 99 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн.

Эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлын үр дүнд:

- 2006-2009 оны 63 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2010-2013 оны 87 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 1999-2013 оны 560 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1990-2013 оны 53 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 2002-2013 оны 11 хадгаламжийн нэгж бүхий тусгай төрлийн дүрс бичлэг,
- 2009-2010 оны 4 гэрэл зургийн,
- 1996-2012 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 10 нэр төрлийн 99 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.

Дээрх данс, бүртгэл, актыг Нийслэлийн Мал эмнэлгийн газрын дэргэдэх ББНШК-ийн 2014 оны 05дугаар сарын 22-ны 01 дугаар хурлаар хэлэлцүүлэн. Нийслэлийн Архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.